

Д.Намдаг “ Үрэгдсэнийг хүлээгч”
зохиолын үйл явдал, орчин нөхцөл,
дүр, хэл найруулгад задлал хийх

8 - р анги

1939 онд Монголын түүхэнд
ямар үйл явдал болсон бэ?



Дэлхийн II дайны эхлэл хэмээн зарим судлаачдын үздэг 1939 оны Халхын голын дайнд агаарын болон хуурай замын өргөн талбарт тухайн үедээ шилдэг зэвсэглэлтэй Японы армийн эсрэг хүнд бэрх тулалдаануудыг Монголын зэвсэгт хүчин анх удаа хийсэн. Дайны явцад нийт 101 томоохон тулаан болж, нийтдээ 74522 хүний хохирол учирснаас 28246 нь амь үрэгдсэн тооцоо бий. Энэ дайнд Монгол Ардын хувьсгалт цэргийн 3 морьт дивиз, бусад анги салбарын 8500 орчим цэрэг дайчид оролцож, Зөвлөлтийн цэргийн хамтаар ялалт байгуулан улс орныхоо хил хязгаар, бүрэн бүтэн байдлыг хамгаалж, тусгаар тогтнолоо бататгаж чадсан билээ. Халх голын дайны ялалт нь тусгаар тогтносон БНМАУ бодитойгоор оршин тогтнож буйг дэлхий дахинд харуулсан юм.

Зохиогчийн товч намтар

Орчин үеийн уран зохиолын гол төлөөлөгчдийн нэг, жүжгийн зохиолч, монголын театрын урлагийн анхдагчдын нэг Д.Намдаг 1911 онд Өвөрхангай аймгийн Тарагт сумын нутагт өртөө улаач Донровын гэр бүлд төржээ. Бага балчир насандаа нутгийнхаа сургуульд элсэн оржээ. 1926 - 1927 онд Герман улсын хэлний бэлтгэлд, 1927 - 1929 онд Германы Вихерсдоф сургуульд Бадарч, Д.Нацагдорж, Пагмадулам, Цэвээн зэрэг нөхдийн хамт суралцаж төгссөн байна.

1934 оноос уран бүтээлээ эхэлж “Алим”, “ Их хурим”, “Цаг төрийн үймээн” , “Шарай голын 3 хаан” зэрэг олон ном зохиол хэвлүүлсэн. 1962, 1983 онд Төрийн шагнал 1971 онд урлагийн гавьяат зүтгэлтэн цол хүртжээ.



Донровын Намдаг

- Зохиолд ямар хэрэг явдлыг
өгүүлж байна вэ?
- Зохиолын хэрэг явдал хэрхэн
эхэлж, хэрхэн өрнөж, хэрхэн
төгссөн бэ?

Зохиолын өгүүлэгдэхүүний бүтэц



Эхлэл хэсэг

1939 оны намар Нямаа өвгөнийд ногоон машинтай цэргийн дарга ирж бага хүүг нь дайнд амь үрэгдсэн тухай гунигт мэдээг хүргэнэ.

Зангилаа

Хүү бэр 2 нь хүү чинь баатар болсон энэ жил ирж чадахгүй гэж хэлж байгаа нь зангилаа

Өрнөл

Өвгөн хүүгээрээ бахархан ярьж өдөр хоногийг тоолон хүлээх болсон төдийгүй хонь хурганы захад гарч бие нь сайжирч байна. Хүсэн хүлээсэн намрын дунд сарын 15 болоход хүү чинь онгоцны нисгэгч болсон дараа жилийн намрын эхэн сарын шинийн нэгэнд ирэхээр болсон гэж дахин хуурч хөөрхмй өвгөн үхэлтэй тэмцэлдэн хүүгээ хүлээж байгаагаар үйл явдал өрнөж байна.

Туйл

Дараа жилийн намрын эхэнд сарын шинийн нэгэнд өвгөн гэрийн хаяанд өдөржин сууж хүүгээ хүлээж байгаа нь туйл юм.

Тайлал

Тэр шөнө өвгөн хүүтэйгээ зүүдэндээ уулзана.

Төгсгөл

Өвгөн үүрээр амьсгал хураав.

Өгүүлэгчийн хүүрнэл болоод захидал, харилцан ярианы учир холбогдлыг шинжлэх

Өгүүллэгт хүүрнэн
өгүүлэгч хэн байна вэ?
Хэддүгээр биеэс өгүүлж
байна ?

Нямаа өвгөнд бусад
хүмүүс хэрхэн хандаж
байгааг харуулсан
хүүрнэн өгүүлэгчийг
зохиолоос олж
бичээрэй.

Нямаа өвгөний дуу
хоолойг мэдэрч байна
уу? Дүрээр дамжуулж
зохиогчийн хэлэхийг
хүссэн үг, дуу хоолойг
батлахыг хичээгээрэй.

Зохиогч зохиолдоо
өгүүлэгчийн
хүүрнэлээс гадна
харилцан яриа,
захидлын хүүрнэл
зэргийг хэрхэн
ашигласныг
ажиглаарай.

Хүүрнэн өгүүлэгч

- Хүүрнэн өгүүлэгч гэдэг нь өгүүллэг тууж дахь түүхийг ярьж буй хүн юм.
Гуравдугаар биеийн хүүрнэн өгүүлэгч нь бүхий л дүрүүдийн хэлж, бодож, хийж байгаа бүхнийг мэдэн дамжуулж байдаг.

Ажлын хуудас

Зохиомжийн нэгж	Жишээ	Тайлбар
Өгүүлэгчийн хүүрнэл		
Харилцан яриа		
Захидлын хүүрнэл		

Дүр

- Зохиолын өгүүлэгдэхүүний гол зангилааг тээж явдаг төлөөлөл хүнийг дүр гэнэ. Уншигчийн зүгээс дүрийг ёс суртахуун , зан төрхийн шинж болоод шийдвэр шаргах оролцоогоор нь гол дүр, сөрөг дүр, туслах дүр гэж ялгадаг. Зохиолч дүрээ амьдруулахын тулд янз бүрийн аргыг хэрэглэдэг.
- Зохиолын гол дүр нь үзэл бодол, үйл хэрэг,эрхэм нандин чанараараа дагуулж асуудлын шийдлийг олж, шийдвэрийг гаргаж буй давуу хүчин юм.
- Эсрэг дүр нь гол дүртэй бүхий л талаараа зөрчилдөж буй хүн буюу сөрөг хүч юм. Харин туслах дүр нь гол дүрийн үзэл бодол, үйл хэргийг дэмжин оролцож байдаг.

Зохиолын дүрүүдийн холбоо хамаарлаар гол ба туслах, сөрөг дүрийг тодорхойлох

- Зохиолд ямар ямар дүр гарч байна вэ? Дүрүүдийг шинжилье

Дүр	Хэлсэн үг яриа, бодол, хийсэн үйлдэл	Хүсэл зорилго	Ямар дүр вэ? Дүгнэх	Дүрийн уншигчдад үзүүлэх нөлөө
Нямаа өвгөн				
Жамьян				
Жамьянгийн эхнэр				
Жаал				
Цэргийн дарга				

- Зохиолд ямар ямар дүр гарч байна вэ? Үйл явдалд дүрүүд хоорондоо хэрхэн холбогдож байгааг тайлбарлаарай.


Дүрүүд	Холбоо хамаарал
Нямаа өвгөн	
Жамьян	
.....	
.....	
.....	
.....	

Зохиолын сэдэв, гол санааг тодорхойлох



Орчин, нөхцөл нь дүрийг тодруулахад хэрхэн нөлөөлж буйг тайлбарлая

Зохиолд үзүүлж буй цаг нь
бодит тодорхой түүхэн цаг
байна уу? Аль эсвэл ерөнхий
эрт нэгэн цаг байна уу?



Үзүүлсэн орон нь бодит
тодорхой газар орон байна
уу? Аль эсвэл ерөнхий
нэгэн орон байна уу?

1939 он Монгол улсын түүхэнд
болсон ямар хэрэг явдлыг сануулж
байна? Зохиогч энэ орон цагийг
сонгон авсны учир зорилго юу вэ?
Эдгээр нь зохиолын дүрийг бүтээхэд
хэр нөлөөтэй байна вэ?

Зохиолын цаг, орон, нөхцөл байдал

	Хэзээ, Хаана, Ямар нөхцөл байдалтай байсан бэ?
Цаг	1939 оны намар
Орон	Монголын говь нутагт
Нөхцөл байдал	Дайны улмаас хагацал үзсэн айл өрхийн шаналант нөхцөл байдал

Өгүүллэгт сонгон үзүүлсэн үйл явдлын цаг нь 1939 оны намар, орон нь монголын говь нутгийн нэгэн малчин айлд болж байна.

Зохиолч энэ орон цагийг сонгосон учир нь дайны хар сүүдрийг үзүүлэх явдал байсан гэвэл харин нөхцөл байдал нь өндөр настай аавын хүүтэйгээ уулзахын хүслэн болоод дайнд амь үрэгдсэн дүүгийнхээ талаар аавдаа хэлэхээс зүрхшээх нэгэн гэр бүлийнхний өмнө тулгарсан нөхцөл байдлыг бүтээсэн байна.

Зохиолч дүрдээ орчинтой нь хэрхэн холбон үзүүлсэн байна бэ? Жамьяны гэрийн доторх орчныг зохиолч нарийн дүрслэн үзүүлсэний гол зорилго юу вэ?



Гэрийн баруун хоймор...

Доодтойд нь суугаа...

Нөгөөтэй нь үнсийг нь хаясан тулганы хажууд...

Түүний дээдтэйд...

Зохиогч Жамьян, түүний эхнэр, жаалхүү, Нямаа өвгөний дүр төрх, байр байдлыг орчин нөхцөлтэй нь уялдуулж илүү тодотгосон.

Зохиолд цаг улирлыг хэрхэн тусган үзүүлсэн байна вэ? Зохиолч намрын улирлын шинж тэмдгийг эрхлэх аж ахуйтай холбон хэрхэн гаргасан байна вэ?

Зохиолч Нямаа өвгөний дүрийг бүтээхдээ ямар нөхцөл байдлын дунд үзүүлсэн байна вэ? Түүний хүсэл зорилготой эсрэгцэж, түүнд саад болж буй ямар хүчин зүйлс байна вэ?

.....


.....

.....

.....

.....

Зоххиогчийн үг сонголт, уран дүрслэлийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах



Зохиогчийн үг сонголт, уран дүрслэлийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах

Нөхцөл байдлыг хурцатган
үзүүлэхийн тулд зохиолч бичил
дүрслэлийг хэрхэн ашигласан байна
вэ? Зохиолоос эш татан
тайлбарлаарай.

“...Уйлах инээхийн алин дээр байгааг
ялгаварлан үл чадан...”-

.....

.....

Зохиолд Нямаа өвгөнийг чих хатуу,
хараа муу гэж үзүүлсэн ч тогоотой
сүүний өрөм загсахыг ажиглан шинжих
өвгөний үйлдлээр зохиолч бидэнд юуг
таниулж байна вэ?

.....

Нямаа өвгөний сэтгэл санаа ямар байна вэ?
Зохиолч Нямаа өвгөний сэтгэл санааны
байдлыг бидэнд дамжуулахдаа үхлийн тухай
ямар үг хэллэгийг хэрхэн илэрхийлснийг
эхээс түүж бичээд үхлийн талаарх монгол
хүний үзэл төсөөллийг тейлбарлаарай.

Зуурын зовлон эдлэх -
Сүнс минь хоргодох -

.....
.....

Зохиогчийн үг сонголт, уран дүрслэлийн учир холбогдлоор далд утгыг тайлбарлах

Зохиол эхлэхэд Нямаа өвгөний сэтгэл санааны байдал харьцангуй тайван байгаагаар үзүүлж байсан бол зохиолын өгүүлэгдэхүүний аль үеэс зохиолч дахин хойшлуулшгүй шахаж шаардсан нөхцөл байдлыг бүтээсэн бэ?

Төгсгөлийн мөрүүдийг дахин уншаад, Нямаа өвгөний сэтгэл санааны байдал болоод хүмүүсийн харилцаа хандлагыг тодорхойлохдоо зохиолоос эшлэн тайлбарлаарай.

Нямаа өвгөний хоосон горьдлого, хүлээлт болоод үхлээс ирж буй уур амьсгалыг дамжуулахдаа зохиолч ямар арга замыг сонгосоныг эш татан тайлбарлаарай.

Зохиолч Нямаа өвгөний амьдралын сүүлчийн өдрийн сэтгэл санааны байдлыг бидэнд дамжуулахдаа нарны цагийг сонгон хэрэглэсэний учир юу вэ? Холбогдох үг хэллэгийг түүж бичээд утгыг тайлбарлаарай.

Нар хөөрч-
Үд өнгөрсөн-

Анхаарал тавьсанд баярлалаа.